

Монгол Улсад банкны тогтолцоо үүсч бэхэжсэний 95 жилийн ойн бэлэг тэмдэг (лого) бүтээх уралдаан

Зорилго: Монгол Улсад банкны тогтолцоо үүсч бэхэжсэний 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан лого зохиох уралдаан зарлаж байна.

Хүлээн авах хугацаа: 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 12 дугаар сарын 11-ний өдрийн хооронд 14 хоногийн хугацаатай явагдах болно.

Логонд тавигдах шаардлага:

- Лого нь Монгол Улсад банкны тогтолцоо үүсч бэхэжсэний 95 жилийн ойн бэлгэдэл байх тул зохиомж төгс байх, орчин үеийн дизайны шийдэлтэй байна.
- Загвар нь видео, ном товхимол, сонин сэтгүүл, ил захидал, марк, сурталчилгааны зурагт хуудас болон бусад материал, хар, цагаан болон өнгөт гадаргуу дээр хэвлэгдэх боломжтой байна.
- Лого нь өндөр нягтралтай (300 pixels/inch-с дээш) байх, жижгээс томруу хувиргахад харьцаа алдагдахгүй үндсэн элементүүдийг харуулна.
- Adobe Photoshop, Corel Draw, InDesign зэрэг программ дээр болон гараар зурж бүтээсэн байж болно.
- Уралдаанд оролцогчид зөвхөн өөрийн зохиосон дизайнаар оролцох бөгөөд бусдын бүтээлээс хуулсан, тэдгээрийн элементийг агуулсан бол шалгаруулалтад оруулахгүй.
- Уралдаанд нэг оролцогч хэдэн ч загвараар оролцож болох бөгөөд бүтээл тус бүрийн илэрхийлсэн утгыг тайлбарласан байна.
- Уралдаанд оролцогч нь овог нэр, холбоо барих утасны дугаар, ажлын болон оршин суугаа хаягаа уралдаанд ирүүлж буй бүтээлийн тайлбар хэсэгт тодорхой бичсэн байна.
- Бүтээлийн эх хувийг буцааж олгохгүй. Шалгарсан бүтээл нь Монголбанкны өмчлөлд шилжинэ.
- Уралдааны бүтээлээ 1600x1200 pixel-ээс дээш хэмжээтэй JPEG өргөтгөлөөр буулгаж, утга санааны тайлбарын хамт lkhagvasuren.by@mongolbank.mn цахим хаягаар ирүүлэх ба хэвлэмэл өнгөт, А4 форматаар Монголбанкны доорхи хаягаар ирүүлнэ.

Шалгаруулалт:

- Шагналын сан 300000 (гурван зуун мянга) төгрөг.
- Шалгаруулалтыг Монгол Улсад банкны тогтолцоо үүсч бэхэжсэний 95 жилийн ойг зохион байгуулах комиссоор хэлэлцэн шалгаруулна.
- Бүтээлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт багтаан шалгарууж www.mongolbank.mn вэб хуудсаар нийтэд зарлах буюу шалгарсан бүтээлийн эзэд рүү эргэж холбогдоно.

Уралдааны материал хүлээн авах хаяг:

Тамгын газар, Монголбанк
Бага тойруу-3, 15160
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот
Монгол Улс
Утас: 321471